



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 01 дүгээр сарын 24
№04 (1300)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

46.	Гэрийн тэжээвэр амьтны тухай	195
47.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	245
48.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	246
49.	Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	250
50.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	251
51.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	253
52.	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай	254
53.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	255
54.	Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	256
55.	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	259

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

56.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 114	262
-----	---	------------	-----

57.	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай	Дугаар 04	266
58.	Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай	Дугаар 06	267
59.	Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай	Дугаар 07	268

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн эрүүл мэндийг хамгаалах, гэрийн тэжээвэр амьтныг бүртгэх, асран хамгаалах, түр харах, үржүүлэх, хүчирхийллээс хамгаалах, эзэнгүй амьтны тоо толгойг бууруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомж

2.1.Гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль³, Зөвшөөрлийн тухай хууль⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Энэ хууль албаны нохойтой холбоотой харилцаанд хамаарахгүй.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“асран хамгаалагч” гэж гэрийн тэжээвэр амьтныг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах болон нохой, муурыг өөрийн нэр дээр бүртгүүлсэн иргэнийг;

3.1.2.“бичил чип” гэж гэрийн тэжээвэр амьтан, түүний асран хамгаалагчийг таньж тогтоох зорилгоор амьтны арьсан доор байрлуулдаг, дахин давтагдашгүй дугаар агуулсан суулгацыг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

³ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 38 дугаарт нийтлэгдсэн.

3.1.3. “гэрийн тэжээвэр амьтан” гэж ашиг шимийг нь ашиглахаас бусад зорилгоор гэршүүлсэн, хүнтэй хамт амьдрах боломжтой Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2, 4.1.3-т зааснаас бусад амьтныг;

3.1.4. “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” гэж гэрийн тэжээвэр амьтанд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оношилгоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нохой, мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийх, бичил чип суулгах, шаардлагатай тохиолдолд унтуулах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан нэгжийг;

3.1.5. “нохой, муур үржүүлэх” гэж нохой, муурыг нэг болон түүнээс дээш удаа үржүүлэхийг;

3.1.6. “нохой, муур үржүүлэгч” гэж энэ хуульд заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ашгийн төлөө хуулийн этгээдийг;

3.1.7. “нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэж нохой, муурын асран хамгаалагч, нохой муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагааг;

3.1.8. “нохойны удмын бичиг” гэж олон улсын байгууллагын албан ёсны гишүүн байгууллагаас олгодог тухайн нохойны гарал үүсэл, эцэг, эх, төрөлт, төрсөн он, сар, өдөр, хүйс, үүлдэр зэргийг заасан баримт бичгийг;

3.1.9. “түр харагч” гэж гэрийн тэжээвэр амьтныг өөрийн хараа хяналтад байлгаж байгаа асран хамгаалагчаас бусад иргэнийг;

3.1.10. “түр байрлуулан асрамжлах газар” гэж төөрсөн, олдсон нохой, муурыг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх хүртэл, эзэнгүй нохой, муурыг асран хамгаалагчтай болгох хүртэл хоол, орон байраар хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулан түр хараа хяналтдаа байлгах зорилгоор энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

3.1.11. “үржил хязгаарлах мэс ажилбар” гэж мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр гэрийн тэжээвэр амьтныг хөнгөлөх, сав, өндгөвчийг авах, үр тогтсон үед савыг үр хөврөлтэй нь авах мэс ажилбарыг;

3.1.12. “эзэнгүй амьтан” гэж бусдын асран хамгаалалт, хараа хяналтаас гадуурх гэрийн тэжээвэр амьтныг.



4 дүгээр зүйл. Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчим

4.1. Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1. энэрэнгүй хандах;

4.1.2. хүчирхийллээс ангид байлгах;

4.1.3. байгалиасаа өөрийн онцлогтой болохыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, халамжлах;

4.1.4. гэрийн тэжээвэр амьтныг гэршүүлэн тэжээж ирсэн монголын ард түмний уламжлалт ахуй, ёс заншил, өв соёлын салшгүй нэг хэсэг болох үндэсний уугуул үүлдрийн нохойтой холбоотой өвөрмөц аж төрөх ёс, түүхэн уламжлалыг хадгалах, нандигнан өвлүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ АСРАН ХАМГААЛАГЧ БОЛОХ ҮНДЭСЛЭЛ, АСРАН ХАМГААЛАГЧ, ТҮР ХАРАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5 дугаар зүйл. Иргэн асран хамгаалагч болох үндэслэл

5.1. Иргэнд гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч болох үндэслэл дараах байдлаар үүснэ:

5.1.1. гэрийн тэжээвэр амьтныг бусдаас хуульд заасны дагуу шилжүүлэн авах;

5.1.2. эзэнгүй амьтныг асран хамгаалалтад авах;

5.1.3. өөрийн гэрийн тэжээвэр амьтны үр төлийг асран хамгаалалтад авах.

6 дугаар зүйл. Асран хамгаалагчид тавигдах шаардлага

6.1. Асран хамгаалагч дараах шаардлагыг хангасан байна:

6.1.1. 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай;

6.1.2. гэрийн тэжээвэр амьтныг хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах орлогын эх үүсвэртэй байх.

6.2. Нохой, муурын асран хамгаалагч энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан сургалтад хамрагдсан байна.

6.3.Иргэн гэрийн тэжээвэр амьтны талаарх ойлголт авах зорилгоор сайн дураараа асран хамгаалагчийн сургалтад хамрагдаж болно.

7 дугаар зүйл.Нохой, муурын асран хамгаалагчийн сургалт

7.1.Нохой, муурын асран хамгаалагчийн сургалтыг хот, суурин газарт энэ хуулийн 7.2-т заасан хуулийн этгээд зохион байгуулна.

7.2.Нохой, муурын асран хамгаалагчийн сургалт зохион байгуулах хуулийн этгээд нь хүсэлтээ мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сургалтын хөтөлбөрийн хамт хүргүүлж, бүртгүүлсэн байна.

7.3.Нохой, муурын асран хамгаалагчийн сургалтын хөтөлбөр дараах агуулгатай байна:

7.3.1.энэ хуульд заасан асран хамгаалагчийн эрх, үүрэг;

7.3.2.нохой, муурын төрөл, үүлдрийн онцлог, хооллолт, эрүүл мэнд, арчилгаа болон холбогдох бусад зөвлөмж, мэдээлэл.

7.4.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь хот, сууринаас бусад газарт энэ хуулийн 7.3-т заасан агуулга бүхий зөвлөмж, мэдээллийг өгнө.

8 дугаар зүйл.Асран хамгаалагч, түр харагчийн эрх

8.1.Асран хамгаалагч дараах эрх эдэлнэ:

8.1.1.бусдын эрхийг зөрчихгүйгээр гэрийн тэжээвэр амьтныг асран хамгаалах;

8.1.2.гэрийн тэжээвэр амьтныг худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлэх;

8.1.3.гэрийн тэжээвэр амьтан тэжээснийхээ төлөө аливаа ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх;

8.1.4.хуульд заасны дагуу олон нийтийн газар, орон сууцны орчны газар, гудамж, талбайд гэрийн тэжээвэр амьтантай чөлөөтэй зорчих;

8.1.5.гэрийн тэжээвэр амьтны амь нас, эрүүл мэндэд бусдын учруулсан гэм хорыг арилгуулахаар шаардах.

8.2.Түр харагч энэ хуулийн 8.1.2-т зааснаас бусад асран хамгаалагчийн эрхийг эдэлнэ.

8.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн⁵ 4.1.12-т заасан хөтөч нохойтойгоо олон нийтийн газар, орон сууцны орчны газар, гудамж, талбай болон олон нийтийн үйлчилгээний газар чөлөөтэй зорчих, нэвтрэх, үйлчлүүлэх эрхтэй.

9 дүгээр зүйл.Асран хамгаалагч, түр харагчийн үүрэг

9.1.Асран хамгаалагч, түр харагч нь дараах үүрэг хүлээнэ:

9.1.1.олон нийтийн газар гэрийн тэжээвэр амьтантай зорчихдоо тухайн амьтны төрөл, биеийн хэмжээнд тохирсон хүзүүвч, хошуувч, цүнх, хөтөлгөө зэрэг зориулалтын хэрэгсэлтэй авч явах;

Тайлбар:энэ заалт нохой салхилах зориулалтын талбайд хамаарахгүй.

9.1.2.гэрийн тэжээвэр амьтан бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

9.1.3.гэрийн тэжээвэр амьтан ашиглан бусад хүн, амьтныг айлган сүрдүүлэхгүй байх;

9.1.4.гэрийн тэжээвэр амьтныг хоол хүнсээр хангах, халдварт өвчин, гэмтэл бэртэл авахаас урьдчилан сэргийлэх;

9.1.5.гэрийн тэжээвэр амьтныг зориулалтын буюу улирлын онцлогт тохирсон, агаар солилцоо сайтай, байгалийн гэрэл нэвтрэх боломжтой, хөдлөх хангалттай орон зай бүхий байр, үүр, орчин нөхцөлөөр хангах;

9.1.6.гэрийн тэжээвэр амьтныг цэвэр, аюулгүй орчинд байлгах;

9.1.7.гэрийн тэжээвэр амьтныг орон сууц, хашаанаас хараа хяналтгүй гарахгүй байх, бусад амьтан орохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

9.1.8.гэрийн тэжээвэр амьтан өвдсөн, бэртсэн тохиолдолд анхан шатны тусламж үзүүлж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хандах, тусламж үйлчилгээ авах.

9.2.Нохой, муурын асран хамгаалагч энэ хуулийн 9.1-д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

9.2.1.нохой, мууранд бичил чип суулгуулж, бүртгүүлэх;
9.2.2.нохой, муурыг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад жил бүр, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад гурваас доошгүй удаа, туулгалтад улирал тутам хамруулах;

9.2.3.нохой, мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэх;
9.2.4.нохой, муурын хүзүүвч, эсхүл цээживчинд асран хамгаалагчтай холбоо барих мэдээлэл бүхий пайз байршуулах;

9.2.5.олон нийтийн газар, авто зам, гудамж, талбай, орон сууцны орчны газар, цахилгаан болон явган шат, орц, хонгилыг нохой, муурын ялгадсаар бохирдуулахгүй байх, бохирдуулсан тохиолдолд орчныг цэвэрлэж, өтгөн ялгадсыг зориулалтын хогийн сав болон цэгт хаях;

9.2.6.нохой, муурыг хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгийн талбайд салхилуулахгүй байх;

9.2.7.нохой, муурыг эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хугацаагаар хараа хяналтгүй орхихгүй байх;

9.2.8.гэр хороолол, амины орон сууц, зуслангийн хашаанд нохойг уях тохиолдолд зориулалтын хүзүүвч, гурван метрээс багагүй урттай гүйлгээ уяа ашиглах;

9.2.9.нохой, муурыг соёлын биет өв, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт болон соёлын өвийн дурсгалын газруудад дагуулж явахгүй байх.

9.3.Нохой, муурыг түр харагч энэ хуулийн 9.2.5, 9.2.6, 9.2.7, 9.2.8-д заасан үүрэг хүлээнэ.

9.4.Энэ хуулийн 9.2.3-т заасан үүрэг монголын үндэсний уугуул үүлдрийн нохойны асран хамгаалагчид хамаарахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ НОХОЙ, МУУРЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ

10 дугаар зүйл.Нохой, муурыг бүртгэлд хамруулах, бичил чип суулгах

10.1.Асран хамгаалагч, нохой, муур үржүүлэгч нь доор дурдсан хугацаанд нохой, муурыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр бичил чип суулгуулж, харьяа баг, хорооны Засаг даргад бүртгүүлнэ:



10.1.1.нохой, муурыг төрснөөс хойш 50 хоногийн дотор;
10.1.2.бичил чип суулгаагүй нохой, муурыг шилжүүлэн авснаас хойш 30 хоногийн дотор.

10.2.Асран хамгаалагч, нохой, муур үржүүлэгч дараах тохиолдолд 30 хоногийн дотор харьяа баг, хорооны Засаг даргад хандаж, нохой, муурын нэгдсэн бүртгэлд өөрчлөлт оруулна:

10.2.1.бичил чип суулгасан, нохой, муурын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн нохой, муурыг шилжүүлж авсан;

10.2.2.нохой, муур үхсэн.

10.3.Нохой, муур үржүүлэгч нь үржлийн нохой, муур болон түүний үр төлийг хуулийн этгээдийн нэр дээр бүртгүүлнэ.

10.4.Нохой, муурын хаягийн бүртгэл нь асран хамгаалагчийн байнга оршин суугаа газрын хаягаар, нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах байрны оршин байгаа газрын хаягаар тус тус тодорхойлогдоно.

10.5.Нохой, муурын бичил чип нь дахин давтагдашгүй дугаар бүхий, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын шаардлага хангасан байна.

10.6.Нохой, муурын бичил чипний стандартыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

10.7.Энэ хуулийн 30.1.4-т заасан нохой, муурын нэгдсэн бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журамд дараах асуудлыг тусгана:

10.7.1.бичил чип суулгасан нохой, муурын асран хамгаалагчийн бүртгэл;

10.7.2.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын бүртгэл;

10.7.3.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт явуулах хуулийн этгээдийн бүртгэл;

10.7.4.алдагдсан нохой, муурын бүртгэл.

10.8.Баг, хорооны Засаг дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь бичил чип унших төхөөрөмжтэй байна.

11 дүгээр зүйл.Нохой, муур бүртгүүлэхэд тавигдах шаардлага

11.1.Нохой, муурын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

11.1.1.иргэний цахим үнэмлэх;

11.1.2.энэ хуулийн 6.1.2-т заасан орлогыг нотлох баримт;

11.1.3.энэ хуулийн 6.2-т заасан асран хамгаалагчийн сургалтад хамрагдсан болохыг нотлох баримт;

11.1.4.нохой, муурын эрүүл мэндийн дэвтэр, бичил чипний дугаар.

11.2.Хот, сууринаас бусад газарт нохой, муурын асран хамгаалагчаар бүртгүүлэхэд энэ хуулийн 11.1.3 дахь заалт хамаарахгүй.

11.3.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 11.1-д заасан баримт бичгийг шалгасны үндсэн дээр нохой, муурын мэдээллийг энэ хуулийн 31.1.1-д заасан бүртгэлийн системд бүртгэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЭЗЭНГҮЙ АМЬТАНТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАА

12 дугаар зүйл.Эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах

12.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг хэрэгжүүлнэ.

12.2.Эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулахад дараах зарчмыг баримтална:

12.2.1.харгис хэрцгий арга хэрэглэхгүй байх;

12.2.2.үржил хязгаарлах аргыг нэн тэргүүнд эрхэмлэх;

12.2.3.олон нийтийн газар, авто зам, гудамж, талбай, хүн амын суурьшлын бүсэд устгахгүй байх;

12.2.4.нийтийн эрүүл мэнд, нийгмийн сэтгэл зүйд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх;

12.2.5.энэ хуульд заасан бусад.

12.3.Эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг зохион байгуулах журмыг энэ хуульд нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга батална.

12.4.Эзэнгүй нохой, муурын тоо толгойг буудаж устгах замаар бууруулахыг хориглоно.

13 дугаар зүйл.Алдагдсан гэрийн тэжээвэр амьтан

13.1.Гэрийн тэжээвэр амьтан алдагдсан тохиолдолд асран хамгаалагч, түр харагч 48 цагийн дотор тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлнэ.

13.2.Алдагдсан гэрийн тэжээвэр амьтныг олсон этгээд нь тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлнэ.

13.3.Алдагдсан гэрийн тэжээвэр амьтныг олсон этгээд тухайн гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч буюу шаардах эрх бүхий этгээдэд буцаан өгөх үүрэгтэй.

13.4.Алдагдсан гэрийн тэжээвэр амьтныг олсон этгээд асран хамгаалагч, нохой, муур үржүүлэгчээс тухайн амьтныг олох, түр харах, хамгаалах, асран хамгаалагчийг олохтой холбогдон гарсан зардлыг шаардах эрхтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ НОХОЙ, МУУР ҮРЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

14 дүгээр зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

14.1.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө хуулийн этгээд эрхэлнэ.

14.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 31.1.2-т заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг тодорхой зааж бичгээр хариу өгнө.

14.4.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

14.4.1.зөвшөөрөл хүссэн өргөдөл;

14.4.2.энэ хуулийн 17.1.1-д заасан шаардлага хангасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны хэмжээ, нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, хаягийн нотлох баримт;



14.4.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;

14.4.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

14.4.5.үржүүлэх нохой, муурын төрөл, үүлдэр, хүйс, тоо толгой, чипний дугаарын мэдээлэл;

14.4.6.цэвэр үүлдрийн нохойны хувьд удмын бичиг.

14.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.

14.6.Энэ хуулийн 31.1.5-д заасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журамд дараах зүйлийг тусгана:

14.6.1.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

14.6.2.нохой, муурын үүлдэр;

14.6.3.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны эрүүл ахуйн шаардлага.

15 дугаар зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл

15.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах үндэслэлээр нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзана:

15.1.1.энэ хуулийн 14.4-т заасны дагуу ирүүлсэн баримт бичгийн бүрдэл хангаагүй тухай зөвшөөрөл хүсэгчид мэдэгдсэн боловч ажлын 21 өдөрт багтаан нэмэлт баримт бичгийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй;

15.1.2.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх орон байр нь энэ хуулийн 17.1.1-д заасан шаардлага хангаагүй;

15.1.3.зөвшөөрөл хүсэгч иргэн, эсхүл ашгийн төлөө бус хуулийн этгээд бол;

15.1.4.зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 19.1.5, 19.1.6-д заасан үндэслэлээр зөвшөөрлөө хүчингүй болгуулсан;



15.1.5.зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах газрын гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүн бол.

16 дугаар зүйл.Нохой, муур үржүүлэгчийн хөтлөх бүртгэл

16.1.Нохой, муур үржүүлэгч нохой, муурын талаар дараах бүртгэлийг хөтөлж, өөрчлөлтийг тухай бүр бүртгэнэ:

16.1.1.төрөл, үүлдэр, тоо толгой, нас, хүйс, чипний дугаар;

16.1.2.нийлүүлсэн нохой, муурын төрөл, үүлдэр, нас, чипний дугаар, нийлүүлсэн он, сар, өдөр;

16.1.3.төрөлт, үр төлийн тоо, хүйс;

16.1.4.нас баралт;

16.1.5.үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэсэн нохой, муурын мэдээлэл;

16.1.6.худалдсан, бусдад шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэн авсан этгээдийн мэдээлэл.

16.2.Нохой, муур үржүүлэгч энэ хуулийн 16.1-д заасан бүртгэлийн хагас жилийн тайланг жил бүрийн 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

17 дугаар зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

17.1.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд дараах нийтлэг шаардлага тавигдана:

17.1.1.нохой, муурыг төрөл, үүлдрийн онцлог, биеийн хэмжээнд тохирсон, хөдөлгөөн хязгаарлахгүй орон зай бүхий талбайтай, агаар солилцоо сайтай, улирлын онцлогт тохирсон, байгалийн гэрэл нэвтрэх боломжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан орон байранд ангилан байрлуулах;

17.1.2.нэг наснаас дээш, найман наснаас доош нохой, муурыг үржүүлэх;

17.1.3.нохой, муурыг жилд нэгээс дээшгүй удаа үржүүлэх;

17.1.4.гэрээний үндсэн дээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, эсхүл малын эмчтэй хамтран ажиллах;

17.1.5.хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 200 метрийн дотор нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулахгүй байх;

17.1.6.мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагыг хангах;

17.1.7.эрүүл ахуйн хөтөлбөртэй байх.

17.2.Нохой, муур үржүүлэгч энэ хуулийн 9.2.3-т зааснаас бусад үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил хүлээнэ.

18 дугаар зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгах

18.1.Нохой, муур үржүүлэгч нь нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргаж мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

18.1.1.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ;

18.1.2.энэ хуулийн 17.1.1-д заасан шаардлага хангасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны хэмжээ, нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, хаягийн нотлох баримт;

18.1.3.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

18.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 18.1-д заасан хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтааж энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэл байгаа эсэхийг хянаж, зөрчилгүй бол зөвшөөрлийн хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.

18.3.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгахаас татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэлийг тодорхой зааж, энэ хуулийн 18.2-т заасан хугацааны дотор бичгээр хариу өгнө.

19 дүгээр зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

19.1.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:



19.1.1.нохой, муур үржүүлэгч хүсэлт гаргасан;
19.1.2.нохой, муур үржүүлэгч хуулийн этгээд татан буугдсан;
19.1.3.нохой, муур үржүүлэгч нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

19.1.4.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлагыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;

19.1.5.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан нохой, муур худалдах, худалдан авах, шилжүүлэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн;

19.1.6.энэ хуулийн 36.2-т заасан хүчирхийллийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг гаргасан;

19.1.7.зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад шилжүүлсэн, худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан;

19.1.8.зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

19.1.9.энэ хуулийн 16.2-т заасан бүртгэлийн тайлан хүргүүлэх үүргээ биелүүлээгүй, эсхүл гурав буюу түүнээс дээш удаа хугацаа хэтрүүлж хүргүүлсэн;

19.1.10.энэ хуулийн 15.1-д заасан зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл тогтоогдсон;

19.1.11.гэрийн тэжээвэр амьтны үзэсгэлэн, худалдаа, тэмцээн уралдааныг зөвшөөрөгдсөнөөс өөр байршилд, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлага хангаагүй нөхцөлд зохион байгуулсан.

19.2.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар болсон тохиолдолд зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг нэн даруй зогсоож, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй нохой, муурыг иргэн, эсхүл энэ хуульд заасан зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд шилжүүлнэ.

**20 дугаар зүйл.Нохой, муур худалдах, худалдан авах,
шилжүүлэх**

20.1.Нохой, муурыг гагцхүү нохой, муур үржүүлэгч худалдах эрхтэй.



20.2.Нохой, муур үржүүлэгч нохой, муурын үр төлийг төрснөөс хойш гурван тун урьдчилан сэргийлэх тарилга болон туулгалтад хамруулсны дараа бусдад шилжүүлнэ.

20.3.Нохой, муурын үр төлийг 60 хоногийн дотор эхээс нь салгах, худалдах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

20.4.Нохой, муур үржүүлэгч нохой, муурыг энэ хуулийн 17.1.1-д заасан шаардлага хангаагүй байр, дэлгүүр, эсхүл гар дээрээс худалдахыг хориглоно.

20.5.Нохой, муурыг энэ хуулийн 6.1.1, 6.2-т заасан шаардлага хангасан иргэн, эсхүл нохой, муур үржүүлэгчид худалдана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЭЗЭНГҮЙ АМЬТАН ТҮР БАЙРЛУУЛАН АСРАМЖЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

21 дүгээр зүйл.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа

21.1.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө бус хуулийн этгээд эрхэлнэ.

Тайлбар:Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах гэдэгт 10-аас дээш нохой, муурыг асран хамгаалагчтай болох хүртэл байрлуулан асрамжлах үйл ажиллагааг ойлгоно.

21.2.Иргэн, хуулийн этгээд түр байрлуулан асрамжлах газраас эзэнгүй амьтныг хүлээн авахыг шаардах эрхгүй.

21.3.Энэ хуулийн 31.1.6-д заасан эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагааны журамд дараах зүйлийг тусгана:

21.3.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

21.3.2.түр байрлуулан асрамжлах газрын хөтлөх бүртгэл;

21.3.3.түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан хүлээн авах, шилжүүлэх талаарх мэдээлэл.

22 дугаар зүйл.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох

22.1.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу олгоно.

22.2.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

22.3.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах үндэслэлээр эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзана:

22.3.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдэл нь хангагдаагүй талаар зөвшөөрөл хүсэгчид мэдэгдсэн боловч ажлын 21 өдөрт багтаан нэмэлт баримт бичгийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй;

22.3.2.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх орон байр нь энэ хуулийн 24.1.1-д заасан шаардлага хангаагүй;

22.3.3.зөвшөөрөл хүсэгч нь иргэн, эсхүл ашгийн төлөө хуулийн этгээд бол;

22.3.4.зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 28.1.5-д заасан үндэслэлээр зөвшөөрлөө хүчингүй болгуулсан;

22.3.5.зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүн нь нохой, муур үржүүлэгчийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан бол.

22.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.

23 дугаар зүйл.Түр байрлуулан асрамжлах газрын хөтөлөх бүртгэл

23.1.Түр байрлуулан асрамжлах газар нь эзэнгүй амьтны талаар дараах бүртгэлийг хөтөлж, өөрчлөлтийг тухай бүр бүртгэнэ:

23.1.1.төрөл, үүлдэр, тоо толгой, нас, хүйс, чипний дугаар;



23.1.2.тухайн амьтныг хэрхэн олж авсан талаарх мэдээлэл;
23.1.3.нас баралт;
23.1.4.үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэсэн нохой,
муурын мэдээлэл;

23.1.5.нохой, муурыг бусдад шилжүүлсэн тохиолдолд
шилжүүлэн авсан этгээдийн мэдээлэл.

23.2.Түр байрлуулан асрамжлах газар энэ хуулийн 23.1-д заасан
бүртгэлийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор мал,
амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад
жил бүр хүргүүлнэ.

24 дүгээр зүйл.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

24.1.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа
эрхлэхэд дараах нийтлэг шаардлага тавигдана:

24.1.1.амьтны төрөл, үүлдрийн онцлог, биеийн хэмжээнд
тохирсон, хөдөлгөөн хязгаарлахгүй орон зай бүхий талбайтай, агаар
солилцоо сайтай, улирлын онцлогт тохирсон, байгалийн гэрэл нэвтрэх
боломжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан орон байранд ангилан
байрлуулах;

24.1.2.гэрээний үндсэн дээр мал эмнэлгийн үйлчилгээний
нэгж, эсхүл малын эмчтэй хамтран ажиллах;

24.1.3.мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагыг
хангах;

24.1.4.эрүүл ахуйн хөтөлбөртэй байх.

24.2.Түр байрлуулан асрамжлах газар энэ хуулийн 9.2.1-д зааснаас
бусад үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил хүлээнэ.

25 дугаар зүйл.Түр байрлуулан асрамжлах газрын эрүүл ахуйн хөтөлбөр

25.1.Түр байрлуулан асрамжлах газрын эрүүл ахуйн хөтөлбөр
дараах баримт бичгээс бүрдэнэ:

25.1.1.эзэнгүй амьтныг төрөл, үүлдрийн онцлог, биеийн
хэмжээ, эрүүл мэндийн байдалд тохируулан түр байрлуулан асрамжлах
газарт хүлээн авах журам;

25.1.2.халдварт өвчтэй эзэнгүй амьтныг тусгаарлах, асрах журам;

25.1.3.түр байрлуулан асрамжлах газарт мөрдөх аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага.

25.2.Түр байрлуулан асрамжлах газар эрүүл ахуйн хөтөлбөрийг ажилтанд танилцуулж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.

25.3.Түр байрлуулан асрамжлах газар иргэдийг эрүүл ахуйн хөтөлбөртэй танилцах боломжоор хангана.

26 дугаар зүйл.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаанд хориглох зүйл

26.1.Түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан худалдах, үржүүлэх үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

26.2.Түр байрлуулан асрамжлах газар эзэнгүй амьтныг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор бусдад шилжүүлэхийг хориглоно.

26.3.Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 400 метрийн дотор эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

27 дугаар зүйл.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгах

27.1.Түр байрлуулан асрамжлах газар нь эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргаж мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

27.1.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ;

27.1.2.энэ хуулийн 24.1.1-д заасан шаардлага хангасан эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулах орон байрны хэмжээ, нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, хаягийн нотлох баримт.

27.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 27.1-д заасан хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтааж

энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан үндэслэл байгаа эсэхийг хянаж, зөрчилгүй бол зөвшөөрлийг анх олгосон хугацаагаар сунгана.

27.3.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгахаас татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэлийг тодорхой зааж, энэ хуулийн 27.2-т заасан хугацааны дотор түр байрлуулан асрамжлах газарт бичгээр хариу өгнө.

28 дугаар зүйл.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

28.1.Эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

28.1.1.түр байрлуулан асрамжлах газар хүсэлт гаргасан;

28.1.2.түр байрлуулан асрамжлах газар татан буугдсан;

28.1.3.түр байрлуулан асрамжлах газар нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

28.1.4.энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;

28.1.5.энэ хуулийн 36.2-т заасан хүчирхийллийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гаргасан;

28.1.6.зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад шилжүүлсэн, худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан;

28.1.7.түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан худалдах, үржүүлэх үйл ажиллагаа эрхэлсэн;

28.1.8.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагааг нэг жилийн хугацаанд явуулаагүй;

28.1.9.зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

28.1.10.энэ хуулийн 23.2-т заасан тайлан хүргүүлэх үүргээ биелүүлээгүй, эсхүл гурав ба түүнээс дээш удаа хугацаа хэтрүүлж хүргүүлсэн;

28.1.11.энэ хуулийн 22.3-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл тогтоогдсон.

29 дүгээр зүйл.Түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан шилжүүлэх

29.1.Түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч эзэнгүй амьтныг энэ хуулийн 6.1.1, 6.2-т заасан шаардлага хангасан иргэнд шилжүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

30 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

30.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

30.1.1.гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

30.1.2.салбарынхаа хөгжлийн чиг баримтлал, бодлого, төлөвлөлтөд гэрийн тэжээвэр амьтныг хамгаалах, эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах арга хэмжээг тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

30.1.3.гэрийн тэжээвэр амьтны үзэсгэлэн худалдаа, уралдаан, тэмцээн зохион байгуулах журам батлах;

30.1.4.нохой, муурын нэгдсэн бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон Цагдаагийн байгууллагын саналыг авч батлах.

31 дүгээр зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

31.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



31.1.1.нохой, муурын нэгдсэн бүртгэл хөтлөх, бүртгэлийн систем хөгжүүлэх;

31.1.2.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хугацааг сунгах;

31.1.3.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын нэгдсэн бүртгэл хөтлөх;

31.1.4.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа энэ хуульд заасан шаардлага, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

31.1.5.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

31.1.6.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

31.1.7.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт зохион байгуулах хуулийн этгээдийг бүртгэх;

31.1.8.нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газрын эрүүл ахуйн хөтөлбөрийг бүртгэж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

31.1.9.гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомжийг сурталчлах, гэрийн тэжээвэр амьтантай холбоотой иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй явуулах.

31.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 16.2, 23.2-т заасан мэдээллийг нийтэд ил тод мэдээлнэ.

32 дугаар зүйл.Цагдаагийн байгууллагын чиг үүрэг

32.1.Цагдаагийн байгууллага хуульд заасан чиг үүргээс гадна алдагдсан, олсон гэрийн тэжээвэр амьтны бүртгэл хөтлөх, бичил чип унших төхөөрөмжөөр асран хамгаалагчийг тогтоох арга хэмжээ авах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

33 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэг

33.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг нэгдсэн удирдлагаар хангах;

33.1.2.харьяалах нутаг дэвсгэрийн нохой, муурын үржлийг хязгаарлах, бичил чип суулгах ажлыг зохион байгуулах;

33.1.3.харьяалах нутаг дэвсгэрийн эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах.

34 дүгээр зүйл.Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

34.1.Сум, дүүргийн Засаг дарга гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

34.1.2.харьяалах нутаг дэвсгэрийнхээ нохой, муурын бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах;

34.1.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг зохион байгуулах;

34.1.4.харьяалах нутаг дэвсгэртээ байрлах нохой, муур үржүүлэгч, түр байрлуулан асрамжлах газрын үйл ажиллагаанд хяналт тавих, гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах.

35 дугаар зүйл.Баг, хорооны Засаг даргын чиг үүрэг

35.1.Баг, хорооны Засаг дарга гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.1.1.харьяалах нутаг дэвсгэрийнхээ нохой, муурын бүртгэл хөтлөх;

35.1.2.харьяалах нутаг дэвсгэрийнхээ эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг хэрэгжүүлэх.

НАЙМДУГААР БҮЛЭГ ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫГ ХАМГААЛАХ

36 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтныг хүчирхийллээс хамгаалах

36.1.Иргэн, хуулийн этгээд гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.

36.2.Дараах үйлдэл, эс үйлдэхгүйг гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийлэл гэж үзнэ:

36.2.1.алах;

36.2.2.асран хамгаалагч, түр харагч гэрийн тэжээвэр амьтныг санаатайгаар хаях, төөрүүлэх;

36.2.3.эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах, гэрийн тэжээвэр амьтан нь эдгэшгүй өвчин, гэмтэлтэй, орчин тойрондоо аюултайгаас бусад тохиолдолд унтуулга хийх;

36.2.4.зодох, тамлах, хэт ачаалуулах;

36.2.5.хэсгийн болон бүтэн мэдээ алдуулах эм, эмнэлгийн хэрэгсэл хэрэглэхгүйгээр мэс ажилбар хийх;

36.2.6.хараа хяналтгүй орхих, өлсгөх, харангадуулсны улмаас үхэлд хүргэх;

36.2.7.гэрийн тэжээвэр амьтныг зодолдуулах, өгөөш, бай болгох, хүчирхийллийн шинжтэй тэмцээн, уралдаан, арга хэмжээ зохион байгуулах, оролцуулах;

36.2.8.гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хортой эм бэлдмэл, химийн бодисоор хордуулах;

36.2.9.нохой, муурыг байнга уях, хөдөлгөөн хязгаарласан орчинд хорих;

36.2.10.биеийн хэмжээ илт зөрүүтэй гэрийн тэжээвэр амьтдыг хооронд нь нийлүүлэх, эсхүл аль нэг гэрийн тэжээвэр амьтны эрүүл мэндэд хохирол учирч болохуйц нийлүүлгийг санаатайгаар хийх;

36.2.11.гэрийн тэжээвэр амьтныг өөр төрлийн амьтантай нийлүүлэх;

36.2.12.гэрийн тэжээвэр амьтан ашиглан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах;

36.2.13.гэрийн тэжээвэр амьтанд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, согтууруулах ундаа хэрэглүүлэх.

36.3.Энэ хуулийн 32.2-т заасан хүчирхийлэлд өртсөн гэрийн тэжээвэр амьтныг эмчлэх зардлыг гаргасан иргэн, хуулийн этгээд хүчирхийлэл үйлдсэн этгээдээс тухайн амьтныг эмчлэхтэй холбогдон гарсан зардлаа нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

36.4.Гэрийн тэжээвэр амьтан бусдын эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тухайн амьтныг албадан унтуулах арга хэмжээ авах ба унтуулахад гарсан зардлыг асран хамгаалагч хариуцна.

37 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийллийг сурталчлахыг хориглох

37.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийллийг сурталчилсан, уриалсан, өөгшүүлэн дэмжсэн, өдөөн турхирсан зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, нэвтрүүлэг, мэдээ бүтээх, нийтлэх, байрлуулах, түгээхийг хориглоно.

38 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтны түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглох

38.1.Гэрийн тэжээвэр амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг ашиг олох зорилгоор боловсруулах, худалдах, худалдан авахыг хориглоно.

39 дүгээр зүйл.Иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

39.1.Гэрийн тэжээвэр амьтны эрхийг хамгаалах талаар иргэн, хуулийн этгээд нь дараах үүрэг хүлээнэ:

39.1.1.гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийллийн талаар эрх бүхий байгууллагад гомдол, мэдээлэл гаргах;

39.1.2.асран хамгаалагч, түр харагчийг гэрийн тэжээвэр амьтан тэжээснийх нь төлөө ялгаварлан гадуурхахгүй байх;

39.1.3.асран хамгаалагч, түр харагчид энэ хуульд заасан үүргээ биелүүлэх шаардлага тавих.

39.2.Иргэн бусдын гэрийн тэжээвэр амьтныг биеэ хамгаалах сэдэл төрүүлэхүйц үйлдэл гаргахыг хориглоно.

39.3.Хүн, хуулийн этгээд гэрийн тэжээвэр амьтныг сугалаа, шагнал, урамшуулалд олгох, олгохоор амлах, сурталчлахыг хориглоно.



**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

40 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

40.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

41 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

41.1.Энэ хуулийн 12.4 дэх хэсгийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хугацаанаас хойш мөрдөнө.

41.2.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:

2024. évi 4/1300. számú választási törvény 1300. § (1) bekezdésének a) pontja alapján:



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “болон бусад хэрэгцээнд зориулан” гэснийг “зорилгоор” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын
Их Хурлын
Төрийн Мэдээлэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай
7.19 дүгээр зүйл нэмсүгэй:

“7.19 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль зөрчих

1.Гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн нохой, мууранд бичил чип суулгуулж, бүртгүүлэх, үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэхээс бусад үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд заасан хугацаанд нохой, муур тус бүрд бичил чип суулгуулж, бүртгүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Асран хамгаалагч нохой, мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүйгээр нохой, муур үржүүлсэн бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон орлогыг хурааж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Эзэнгүй амьтныг түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүйгээр гэрийн тэжээвэр амьтныг түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Нохой, муур худалдах, худалдан авах, шилжүүлэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон орлогыг хурааж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



7.Түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтныг худалдах, үржүүлэх үйл ажиллагаа эрхэлсэн бол хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Гэрийн тэжээвэр амьтныг үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх нийтлэг шаардлагыг удаа дараа зөрчсөн бол хуулийн этгээдийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Эзэнгүй амьтныг түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх нийтлэг шаардлагыг удаа дараа зөрчсөн бол хуулийн этгээдийг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийлэл үйлдсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийллийг сурталчилсан, гэрийн тэжээвэр амьтны гаралтай түүхий эдийг ашиг олох зорилгоор боловсруулсан, худалдсан, худалдан авсан, гэрийн тэжээвэр амьтныг сугалаа, шагнал, урамшуулалд олгох, олгохоор амлах, сурталчилсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Илдэгч Фолг_оа Нолл

Хэргийн үндэслэл

2024 оны 04 сарын 10 - өдөр

Хэргийн үндэслэл

1. Хэргийн үндэслэл...

2. Хэргийн үндэслэл...

3. Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...

4. Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...

5. Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...

6. Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...

7. Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “тэжээвэр амьтад” гэсний дараа “, гэрийн тэжээвэр амьтад” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Голд Ог Нойл

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.57 дахь заалт:

“5.1.57.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах.”

2/21 дүгээр зүйлийн 21.1.48 дахь заалт:

“21.1.48.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 300000 төгрөг, зөвшөөрлийг сунгахад 150000 төгрөг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



Мэдэгдэл Фолд_02 Нөдөл

2024 оны 4 сарын 10 - өгдөг

Хуульчилсан үндэс

Хуульчилсан үндэс
Хуульчилсан үндэс
Хуульчилсан үндэс

1. Хуульчилсан үндэс... Хуульчилсан үндэс

2. Хуульчилсан үндэс

3. Хуульчилсан үндэс... Хуульчилсан үндэс

4. Хуульчилсан үндэс

5. Хуульчилсан үндэс... Хуульчилсан үндэс

6. Хуульчилсан үндэс... Хуульчилсан үндэс

Хуульчилсан үндэс
Хуульчилсан үндэс



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.21 дэх заалтын “нохойны” гэснийг “нохой, муурын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongrel Folio_02.html

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “хараагүй хүн” гэснийг “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мөдгөрх Фолд, 02 НӨ11

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶᠡᠬᠡ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠵᠢᠭᠢᠯᠢ. ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ

ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠵᠢᠭᠢᠯᠢ. ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ

ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠵᠢᠭᠢᠯᠢ. ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ

ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠵᠢᠭᠢᠯᠢ

ᠬᠡᠭᠡᠳᠡᠭᠡᠷ ᠵᠢᠭᠢᠯᠢ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу нохой, муурын асран хамгаалагчийн сургалт зохион байгуулах хуулийн этгээдийг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор бүртгэж эхэлнэ.

2 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нохой, муурын бичил чипний стандартыг Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор тогтооно.

3 дугаар зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасны дагуу нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор баталж, нохой, муурын нэгдсэн бүртгэлийн системийг нэг жилийн дотор хөгжүүлж, ашиглалтад оруулна.

4 дүгээр зүйл. Асран хамгаалагч, нохой, муур үржүүлэгч Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу нохой, муурын нэгдсэн бүртгэлийн систем ашиглалтад орсноос хойш зургаан сарын дотор нохой, муурыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид бичил чип суулгуулж, харьяа сум, баг, хорооны Засаг даргад бүртгүүлнэ.

5 дугаар зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дараа дагаж мөрдөнө.

6 дугаар зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож эхэлнэ.

7 дугаар зүйл. Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор Гэрийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 114

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг
хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал
батлагдсаны 75 жилийн ойд зориулсан
Улсын Их Хурлын хүндэтгэлийн
хуралдаантай холбогдуулан авах
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод нийцэж байгаа эсэх талаар болон хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/, Хүний эрхийн дэд хороо /Ц.Мөнхцэцэг/-нд даалгасугай.

2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

а/“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-2”-ыг батлан, хэрэгжүүлэх;

б/Нэгдсэн Үндэстний Байгууллагын 80 жилийн ойг угтаж 2025 оныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн жил болгох уриалга гаргах чиглэлээр ажиллах;

в/хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх талаар санал боловсруулан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулах;

г/хүний эрхийн мэдлэг олгох, сургах, чадавхжуулах чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа Ази, Номхон далайн бүсийн

төвийг Монгол Улсад байгуулах санаачилга гаргаж, шийдвэрлүүлэх талаар идэвхтэй ажиллах;

д/хүний эрхийн боловсрол, мэдлэгийг хүүхэд, залуучуудад ойлгуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг эрчимжүүлж, эрх, үүрэг, хариуцлагын тухай сургалт зохион байгуулах, хүний эрхийн ойлголт, мэдлэгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах;

е/хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж болзошгүй аливаа шалтгаан, нөхцөлийг урьдчилан судлан тогтоож, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хийдэл, зөрчлийг арилгах талаар хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ё/Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан хүний эрхийн гэрээ, конвенц, пактуудаар хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх хүний эрхийн төлөв байдлын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хороо, түүний бүтцийн бусад байгууллагуудад тайлагнах механизмд парламентын оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ж/Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас гаргасан тогтоолын хүрээнд ахмад настны эрхийн асуудлаар тусгайлсан баримт бичиг батлах санаачилгыг Монгол Улс дэмжиж байгааг зохих журмын дагуу холбогдох байгууллагад мэдэгдэх;

з/олон улсын гэрээ, конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг эрчимжүүлж, олон улсын гэрээний заалтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх.

3.Төрийн албан хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, мэдрэмжийг шалгах, үнэлэх талаар холбогдох дүрэм, журам, зааврыг хамтран боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөл /Б.Баатарзориг/, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /Д.Сүнжид/-т тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16^{1.2} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр Лхагважавын Гангэрэл, Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Ланганы Отгонтуяа, Равсалын Рэнцэнбазар, Нинжбатын Ууганбаатар, Амаржаргалын Энхбат, Намжилдоржийн Энхбаяр нарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian Folio_04 Угд Ноговд 04 Download

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠲᠤᠭᠠᠰ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийн бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон бүсүүдийн харьцангуй бие даасан, харилцан уялдаатай тогтолцоог бүрдүүлж, бүс нутаг, хот, хөдөөг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын нутагшилт, суурьшлын олон төвтэй тогтолцоог бий болгох, нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, иргэдийн орон нутагт шилжин суурьших таатай нөхцөлийг хангах зорилгоор Улсын Их Хурлаас баталсан дараах бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдээс санал авах, байр суурийг нь сонсох ажлыг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд зохион байгуулахыг Улсын Их Хурлын гишүүдэд даалгасугай:

1/Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явц, үр дүнг танилцуулах, шинэчлэн боловсруулахтай холбогдуулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

2/Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан бүс, орон нутаг, нийслэл Улаанбаатар болон дагуул хотыг хөгжүүлэх зорилтыг тайлбарлан таниулах, хэлэлцүүлэх;

3/Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан боомтын болон хот, хөдөөгийн сэргэлтийн зорилт, хэрэгжилтийн явцыг танилцуулж, хэлэлцүүлэх.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдээс санал авах ажлыг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч, хамтран зохион байгуулах, холбогдох зардлыг шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайлан, лавлагаа, бусад шаардлагатай мэдээлэл бүхий гарын авлагыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бэлтгэх;

2/Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох, Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийг тогтоох асуудлаар эдийн засгийн форумыг бүсчлэн зохион байгуулах.

3.Энэ тогтоолын 1 дэх заалтын хүрээнд хийсэн уулзалт, хэлэлцүүлэг, тайлбарлан таниулах ажлын дүн, саналыг нэгтгэн Улсын Их Хуралд 2024 оны 03 дугаар сард багтаан танилцуулахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5

Индекс: 200003